



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/52

Алтай хот

**Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн
өвсийг хямдралтай үнээр худалдан
борлуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

- 1.Аймгийн аюулгүйн нөөцөд 2020 онд бэлтгэсэн 40 тонн буюу 2000 боодол өвсийг нэг боодлыг 6,500 төгрөгөөр худалдан борлуулсугай.
- 2.Шарга сумд бэлтгэсэн аймгийн аюулгүйн нөөцийн өвсний үнийн зөрүүг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу данс бүртгэлд тусгахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т зөвшөөрсүгэй.
- 3.Өвсийг 2 дугаар сард багтаан малчдад худалдан борлуулж, орлогыг аймгийн гамшгийн сангийн дансанд төвлөрүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т даалгасугай.
- 4.Өвсийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар), Онцгой байдлын газар (Ц.Лувсанжамц), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
- 5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

